

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН ТОВЧ ТАЙЛАН

### НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тавдугаар хуралдаан хуралдаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн жилийн ажлын тайлан, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилт, аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, хамгаалалтын бүс тогтоох тухай, аймгийн 2022 оны төсвийг тус тус хэлэлцэн, шийдвэр гаргалаа.

Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Бага насны хүүхдийг дэлгэцийн донтолтоос сэргийлэх” аян тус аймагт нээлтээ хийж, 31 цэцэрлэгийн 2900 хүүхэд хамрагдан, мэдээлэл авлаа. Мөн хүүхдүүдэд “Дэлгэцээс холдуулах дадлууд” ном тарааж, мэдээ мэдээллээр хангалаа.

Аймгийн Засаг дарга Дотоод хэргийн их сургуулийн удирдлагуудтай Улаанбаатар хотод уулзалт зохион байгуулж, тус сургуулийн нэрэмжит нэг сая модыг тус аймагт тарьж, ургуулах, боловсролын салбарт хамтран ажиллаж, магистр, докторын хөтөлбөр хэрэгжүүлэх, аймгийн ахлах ангийн сурагчид, залуучууд, иргэдэд ёс суртахуун, эх оронч үзэл, эрх зүйн чиглэлээр сургалт нөлөөллийн ажлуудыг хамтран зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарын санаачилгаар 2 дахь жилдээ зохион байгуулагдаж буй Улаанбаатар хотод амьдарч буй нутгийн иргэддээ өвлийн хүнс хүргэх “Хүргэлт-2” арга хэмжээг зохион байгуулж, 800 орчим өрхийн 140 тонн махыг хүргэлээ.

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга, хурандаа Х.Батсайханаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллаж, тус аймагт байгуулагдаж байгаа Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагчаар томилогдсон Монгол Улсын гавьяат барилгачин, хурандаа Б.Энхбаярыг аймгийн удирдлагуудад танилцуулж, санал солилцлоо.

Газар тариалан ойн салбарын зөвлөгөөн зохион байгуулж, “108 сая мод тарьж, ургуулах” аяны хүрээнд сумдын Засаг дарга нартай мод тарьж, ургуулах хариуцлагын гэрээ байгуулан, “Техник дундын үйлчилгээний бааз байгуулах” зорилгоор худалдаж авсан техник, тоног төхөөрөмжүүдийг аймгийн Хөдөө аж ахуйн газарт хүлээлгэн өглөө.

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 12А ангийн сурагч У.Ану-Үжин “байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчин “төрөлд Монгол улсын “Оны онцлох хүүхэд” - ээр шалгарч, үе тэнгийнхнээ манлайллаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан шалгалтын ажлын хэсэг тус аймагт ажиллах үеэр сум, агентлагийн удирдлагуудтай цахим хурал зохион байгуулж, хуралд нийт 52 албан хаагч хамрагдаж, мэдээлэл авлаа.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг болон 15 байгууллагын дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн тайланг үнэлж, дүгнэлээ.

Мөн сумын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Б/95 дугаар тушаалаар томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

Үндэсний бичгээ дээдлэгч сум, байгууллага хамт олныг шалгаруулсан тухай тайланг Соёлын яаманд хүргүүллээ.

**Төрийн үйлчилгээний чиглэлээр:** Үйлчилгээний нэгдсэн төвд 7 байгууллагын 14 ажилтан 157 нэр төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 1600 гаруй иргэнд нэг цэгээс хүргэлээ.

**Өргөдөл гомдлын талаар:** Тайлант хугацаанд нийт 8 өргөдөл бичгээр ирснээс 2 өргөдлийг шийдвэрлэж, 6 өргөдөл хяналтын хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт 25.0 хувьтай байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 12 дугаар сарын байдлаар нийт дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 42 гомдол, санал, хүсэлтийг Говь-Алтай e-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Шийдвэрлэж хариу өгсөн 39, хугацаандаа судлагдаж байгаа 3 өргөдөл байгаа бөгөөд шийдвэрлэлт 92.9 хувьтай байна.

**Цахим үйлчилгээний талаар:** E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр нийт 63 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож байна. Тайлант хугацаанд 37 иргэнд төлбөртэй, 111 иргэнд төлбөргүй, нийт 148 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчиллээ.

Нийт [WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN](http://WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN) цахим мэдээллийн системээр үзүүлсэн лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээний хураамж 41000 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүллээ.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг иргэдэд танилцуулах, шаардлагатай лавлагаа тодорхойлолтуудыг нэг шатлалаар богино хугацаанд авах, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг тогтмол өгч ажиллалаа.

Иргэдийн хүсэлтээр хувийн мэдээллээр нь бүртгэл үүсгэж, хэрэгцээтэй лавлагаа тодорхойлолтуудыг 184 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Сумдын цахим мэдээлэл лавлагааны дүнг нэгтгэж, тайлан мэдээг Харилцаа холбооны зохицуулах хороонд сар бүрийн 05-ны дотор хүргүүлж байна.

Монгол улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон салбар хариуцсан Засгийн газрын гишүүн сайдуудтай болон Үндэсний хөгжлийн газрын даргатай аймгийн Засаг даргын 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хүргүүллээ.

Мөн аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны хурлын тэмдэглэлийн хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг хүргүүллээ.

Боловсролын салбарын Шилэн дансны хуулийн хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ хийж, босоо удирдлагатай 14 агентлагийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээг харьяалагдах дээд шатны байгууллагад нь хүргүүллээ.

#### ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн аймгийн 2021 оны жилийн эцсийн тайлан, илтгэлийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад, Авлигын эсрэг хууль тогтоомж, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу 2021 онд зохион байгуулсан ажлын тайлан, аймгийн Засаг даргын Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2021 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн биелэлтийг, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны тайланг Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус хүргүүллээ. Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс e-khutuch.mn цахим хуудсанд төрийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг шинэчлэн байршуулахтай холбоотойгоор мэдээллийг шинэчлэн гаргаж, албан бичгээр хүргүүллээ.

**Архивын тасаг:** Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 426 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 128500 хуудас баримт хувилж олшруулан, 11098.0 мянган төгрөг, хүн амын тооллогын лавлагааг <https://e-archives.gov.mn> программаар нийт 55 иргэний захиалгыг Үндэсний төв архивт илгээж, хариуг иргэдэд хүргэн, 192.5 мянган төгрөг, нийт 11290.5 мянган төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүллээ.

“Гуулин-Эрдэнэ” ХХК-ийн гүйцэтгэсэн Уламжлалт анагаах ухааны төвийн барилгын засвар, Төгрөг сумын ХААН банкны шинэ барилга, Алтай хотын авто зам дагуух явган хүний засвар шинэчлэлийн ажлын холбогдох баримт бичгээр бүрдүүлсэн 15 хадгаламжийн нэгж, нотариатч Б.Нандин-Эрдэнийн 75 хадгаламжийн нэгжийг тус тус сан хөмрөгт хүлээн авлаа.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** 2021 оны 12 дугаар сард хүүхдийн тэтгэлгийн нийт 129 гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулан 3 гүйцэтгэх баримт бичгийг харьяаллын дагуу шилжүүлж, 2 гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчийн хүсэлтийн дагуу буцаах ажиллагаа явуулан 16 тэтгэлгийг дуусгавар болгон, 108 хүүхдийн тэтгэлгийн үлдэгдэлтэй ажиллаж байгаа бөгөөд хаяг тодорхойгүй тэтгэлэг төлөгч нарыг Цагдаагийн байгууллагын ASAP санд бүртгүүлэн хамтран ажилласнаар 3 тэтгэлэг төлөгчийн хаягийг тогтоон харьяаллын дагуу шилжүүлэн 7 тэтгэлэг төлөгчийг олж тогтоон хуримтлагдсан тэтгэлгийг төлүүлж үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгүүдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг жигд зохион байгуулан ажиллаж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 9 хоригдолд холбогдох 43 гүйцэтгэх баримт бичгийн 96415.0 мянган төгрөгийн хохиролд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулан, 3 гүйцэтгэх баримт бичгийн 22310.5 мянган төгрөгийн төлбөртэй 3 хоригдол хорихоос суллагдан хасагдаж, хоригдлыг ажлын байраар ханган

хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх талаар хорих ял эдэлж буй хорих ангиуд руу албан бичгийг хүргүүлэн, хоригдлын ар гэр болон хөдөлмөрийн хөлснөөс төлбөрийг төлүүлэн, нийт 7 гүйцэтгэх баримт бичгийн 19107.7 мянган төгрөгийг бүрэн дуусгавар болгож цахим бүртгэлд төлөлтийг бүртгэн, хорих ял эдэлж буй ангиудын холбогдох албан хаагчдад төлбөр төлөлтийн мэдээллийг тухай бүр хүргүүлэн 6 хоригдлын 33 гүйцэтгэх баримт бичгийн 54996.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Тайлант хугацаанд шинжилгээний объектын тоо 14, хэргийн газрын үзлэгт 4 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 4, мөрдөн шалгах бусад ажиллагаанд цогцосны үзлэг 4, задлан шинжилгээ 4-ийг тус тус хийлээ. Мөн шинжилгээний 11, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 120, нийт 131 гэрэл зураг авсан ба химийн шинжилгээ 8, биологийн шинжилгээ 4, нийт 12 тусгай шинжилгээ хийсэн.

**Улсын бүртгэлийн хэлтэс:**Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн сангийн баяжилтыг тухай бүр хийж байна.

Тайлант хугацаанд 498 лавлагаа олгож, гадаад паспорт захиалга 14, шинээр 31, дахин 12, нийт 43 хуулийн этгээдийг бүртгэн гэрчилгээ олголоо.

Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 281 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэн, бүртгэлийн үйлчилгээний хураамж 2637.6 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 142.4 мянган төгрөг, татварын орлого 27036.6 мянган төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Тайлант хугацаанд улсын бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 35 иргэнд 7000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан. Мөн иргэний бүртгэлийн 6, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 1, хуулийн этгээд 1, нийт 8 дүгнэлтээр 11 бүртгэлийн зөрчлийг арилгаж шийдвэрлэлээ.

## ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

**Аймгийн төсөв санхүүгийн чиглэлээр:** Орон нутгийн төсөвт 8793.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 10135.0 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 115.0 хувиар, улсын төсөвт 2185.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 2415.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 110.5 хувиар тус тус биелүүллээ.

Аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсөв болон тодотгосон төсвийг нэгтгэн төсвийн хуваарийг Засаг даргаар батлуулж сумдад 12492.1 сая төгрөгийн, орон нутгийн шууд харилцагч байгууллагуудад 9404.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 38078.0 төгрөгийн санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олголоо.

**Худалдан авах ажиллагаа:** Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн байдлаар 12038.7 сая төгрөгийн 98 төсөл арга хэмжээг төлөвлөж, 97 арга хэмжээг хялбаршуулсан буюу цахимаар зарласан. Төлөвлөсөн тендер шалгаруулалтаас зарласан тендер шалгаруулалт 136, цахим тендер шалгаруулалт 159, эрх шилжиж ирсэн тендер шалгаруулалт 25 байна.

АЗ гэрчилгээ олгох цахим сургалтыг Төрийн худалдан авах ажиллагаа, сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж, 13 иргэн хамрагдан, 12 иргэн эрхээ авлаа.

**Өмчийн харилцааны талаар:** Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн бүртгэлтэй автомашины судалгааг нэгтгэн гаргав. Дахин дуудлагын худалдаа явуулах, дансны залруулга хийх, хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх, хөрөнгө акталж данснаас хасах, үнэ тогтоон худалдан борлуулахыг зөвшөөрөх, худалдах хөрөнгийн жагсаалт баталж, худалдах доод үнийг тогтоох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрүүллээ.

## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

**Хөдөө аж ахуйн салбарт:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар тариалан, жимс, жимсгэнэ” төсөл арга хэмжээ, 108 сая мод тарьж ургуулах аяныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 12 багц ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар орон нутгийн өмчийн газарт хүргүүллээ.

2021 оны “Мал, тэжээвэр амьтны тооллого”-ыг 12 дугаар сарын 7-ны өдрөөс 17-ны өдрүүдэд зохион байгуулж, урьдчилсан байдлаар нийт 2988.8 мянган мал тоологдоод байна.

Улсын хошой аварга малчин болон аварга малчин, тариаланчдын материалыг сумдаас авч шалгаруулж, улсын хошой аварга малчин 3, аварга малчин 11, аварга тариаланч 1, нийт 15 малчны материалыг ХХААХҮЯаманд хүргүүллээ.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Тайлант хугацаанд шүлхий өвчний шинээр голомт нэмэгдээгүй, мал нэмж өвчлөөгүй бөгөөд нийт 9 сум, 22 баг, 23 голомт, 191 өрхөд халдвар бүртгэгдэж, 1058 үхэр, 2557 хонь, 3852 ямаа, нийт 7467 мал өвчилсний 7446 буюу малын 99.6%-д малын эмнэлзүйн шинж тэмдэг арилсан ба нийт өвчилсөн шинж тэмдэг арилсан байна.

Шүлхий өвчний голомтын болон сэжигтэй бүсийн 381999 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийж, 185.6 кг бодис зарцууллаа.

Хяналтын постоор дамжин өнгөрсөн 1141 тээврийн хэрэгслийн 22820 м2 талбайд халдваргүйтгэл хийж, 11.4 кг бодис зарцууллаа. Аймгийн хэмжээнд 28 пост ажиллаж байна.

**Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:** Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс зээл олгохоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлэсний дагуу 8 иргэн, аж ахуйн нэгжид 245.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, үйл ажиллагааг нь дэмжлээ.

## ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

**Газрын харилцааны чиглэлээр:** Аймгийн хэмжээнд 15403 га талбай бүхий 1217 нэгж талбар газарт ашиглах, эзэмшүүлэх, өмчлүүлэхээр төлөвлөж, газар зохион байгуулалтын системд, 18 сумын 138 нэр бүхий нутаг дэвсгэрт 3402614.3 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан нь нийт газар нутгийн 24.05 %-

ийг эзэлж байгаа бөгөөд кадастрын нэгдсэн мэдээллийн системд бүртгэж орууллаа.

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:** Азийн хөгжлийн банкны Япон сангийн буцалтгүй тусламжийн 441.7 сая төгрөгийн санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийн “Ариутгал үйлчилгээний төв” тасгийн барилгын ажлыг “Эм Ай Эс Эс” ХХК-аар, Япон сангийн буцалтгүй тусламжийн 397.2 сая төгрөгийн санхүүжилтээр Есөнбулаг сумын хог хаягдлын шинэ хяналттай 2 дугаар зэргийн ландфиллийн байгууламжийн ажлыг “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-аар, НҮБ-ын Хүүхдийн сан болон сумын орон нутгийн хөгжлийн сангийн нийт 238.4 сая төгрөгийн санхүүжилтээр Тонхил сумын халуун усны барилгын ажлыг “Аранжин-Алтай” ХХК-аар, Эрдэнэ сум орон нутгийн хөгжлийн сангийн 350.0 сая төгрөгийн санхүүжилтээр спорт заалны барилгын ажлыг “Ивээлт алдар” ХХК-аар, “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил төсөл”-ийн хүрээнд барих-ашиглах-шилжүүлэх гэрээний нөхцөлтэйгөөр Шарга сумын төвийн нэгдсэн халаалтын системийн ажлыг “Агар галдай” ХХК өөрийн хөрөнгөөр, Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Хан-Алтай” алтны ордны төслийн хүрээнд хийгдсэн 600 м3 багтаамжтай шатахуун түгээх станцын барилга угсралтын ажлыг “Монторх” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн байнгын ашиглалтад орууллаа.

Барилга, хот байгуулалтын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны өдрийн 1/1412 дугаар албан бичгээр, мөн 2022 оны хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/1482 дугаар албан бичгээр болон [lkhamaa6788@gmail.com](mailto:lkhamaa6788@gmail.com) цахим хаягаар, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор баталсан “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Барилга, хот байгуулалтын яам, Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-т 12 дугаар сарын 20-ны өдрийн 1/1420 дугаар албан бичгээр болон [munkhtsetseg@tosk.gov.mn](mailto:munkhtsetseg@tosk.gov.mn) цахим хаягаар, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхаг байгуулахаар төлөвлөж буй Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах Ардын дуу бүжгийн “Алтай” чуулга, аймгийн Нутгийн удирдлагын ордон, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын барилгуудын өмч хөрөнгийн бүртгэлийн мэдээллийг Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлд 12 дугаар сарын 01-ний өдрийн 2/1331 дугаар албан бичгээр тус тус хүргүүлээ.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хөнгөлттэй зээлийн гэрээний нөхцөлөөр 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах, дулааны станц барих төслийн хүрээнд тендерт оролцогчдод тодорхой мэдээлэл өгөх, төслийн барилга угсралтын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор дулаан үйлдвэрлэгчдээс 2018 оноос хойш дулаан хангамжид холбогдсон болон холбогдохоор төлөвлөж буй хэрэглэгчдийн судалгааг М1 маягтаар, аймгийн барилгын материал үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагуудын цар тахлын дараах үеийн барилгын материалын бодит үнэ өртгийг тооцож М2 маягтаар гарган Төслийн нэгжид [info-10aimag@energy.gov.mn](mailto:info-10aimag@energy.gov.mn), [btuya64@gmail.com](mailto:btuya64@gmail.com) цахим хаягаар хүргүүлээ.

Засгийн газрын 2019 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-д Тайшир сумын нутагт байрлах ус цэвэршүүлэх эргийн толгойн байгууламж, дундын өргөлтийн насос станц, Алтай хотын төвд байрлах даралтат усан сан, нөөц эх үүсвэр, Харзатын ундны усны эх үүсвэр (худаг) зэрэг барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад оруулах тухай хүсэлтийг 12 дугаар сарын 22-ны өдрийн 1/1429 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд ДНТ ХХК-аар гүйцэтгүүлсэн Баянхайрхан, Харзат, Индэрт багуудын хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн шугам сүлжээний холбох ажлын зураг төсвийн магадлалын дүгнэлтийн нэгтгэлд баталгаажсан цахилгаан, ариутгах татуурга, холбоо дохиоллын зардлыг орхигдуулсан байгааг залруулах хүсэлтийг 12 дугаар сарын 20-ны 1/1409 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүллээ.

Тус аймагт хэрэгжүүлэхээр 2022 оны төсөвт тусгагдаж, Төрийн худалдан авах ажиллагааны газарт ХАА зохион байгуулахаар эрх нь шилжсэн цэвэр усны шугам сүлжээний Алтай хотын 1.5 км цэвэр усны төв магистраль шугам сүлжээний шинэчлэх, Халиун, Бугат, Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний нэгдсэн систем, уурын зуухны барилга, Харзат, Индэрт багийн гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт, Дэлгэр, Халиун, Цээл сумын 100 ортой дотуур байр, Халиун сумын 250 суудалтай соёлын төвийн барилга, Чандмань сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төслийг Төрийн худалдан авах ажиллагаа газар, Барилга, хот байгуулалтын яаманд тус тус хүргүүллээ.

**Нийтийн аж ахуйн талаар:** Цэвэр усны шугам сүлжээ, тоног төхөөрөмжтэй холбоотой 16 дуудлага, бохир усны шугам сүлжээ, тоноглолтой холбоотой 25 дуудлага тус тус ирснийг бүрэн барагдуулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллалаа. Тайлант хугацаанд Алтай хотын иргэдэд нийт 11970 м<sup>3</sup> усыг түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжид 9575.2 м<sup>3</sup> бохир усыг өөрийн картандаа хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд 0,42 м<sup>3</sup> усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулж хогийн талбайд хаялаа.

**Агаарын тээвэр:** 2021 оны 12-р сард Аэромонголиа ХХК-ийн 5, Mongolian airways 1, нийт 6 нислэг болон бэлтгэл аэродромын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг ханган нисэх буудлын үйлчилгээ үзүүллээ.

Тайлант хугацаанд Алтай-Улаанбаатарын чиглэлд 106 зорчигч, 1985 кг тээш, 33 ширхэг гар тээшинд аюулгүй байдлын үзлэг шалгалт хийж, тээвэрлэхийг хориглосон эд зүйлсийг зохих журмын дагуу шийдвэрлэлээ. Улаанбаатар-Алтай нийт 101 зорчигч, 3841 кг тээш тээвэрлэгдэж ирсэн байна.

Агаарын хөлөгт үзүүлэх транзит үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний удирдлага, нислэгийн мэдээллийн үйлчилгээ, холбоо, навигаци, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээнд зөрчил дутагдал гаргаагүй болно.

**Техникийн хяналтын үзлэг:** 12 дугаар сарын 20-ны өдрөөс 24-ний өдрүүдэд техникийн хяналтын үзлэг хийж, 101 тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

**Хот хоорондын зорчигч тээвэрлэлт:** Хот хоорондын зорчигч тээвэрлэлт Алтай-Улаанбаатар болон Улаанбаатар-Алтай чиглэлд нийт 727 зорчигч тээвэрлэн үйлчиллээ.

**Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр:** Сумдад ПРС-125, 124-р станцуудад 2021 оны жилийн эцсийн тооллого хийлээ. Тайшир, Жаргалан, Баян-Уул, Хөхморьт, Дарви, Тонхил сумдад моторын үзлэг үйлчилгээ хийж норм тогтоох Мобиком, Скайтелийн захиалгат ажил хийгдлээ. Шинээр УРС-123-д 150 а/ц 1 групп 4 ширхэг батерейг суурилууллаа.

#### ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

**Боловсролын чиглэлээр:** Боловсролын газраас санаачилан төсөлд суурилсан сургалтын аргазүйг нэвтрүүлэх, бага насны хүүхдийг дэлгэцийн донтолтоос сэргийлэх, эцэг, эх, хүүхдийн амьд харилцааг бий болгох, номтой танилцуулах зорилгоор “Номтой нөхөрлөө” төсөлт үйл ажиллагааг 2 сарын турш зохион байгуулж, нэгдсэн тайланг хэлэлцэн, 28 сургуулийн захирал, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, 31 цэцэрлэгийн эрхлэгч оролцож, мэдээлэл солилцлоо.

БШУЯ болон ДЗМОУБ-тай хамтран зохион байгуулж байгаа “Хүмүүжлийн эерэг арга” сургагч багш бэлтгэх үндэсний хэмжээний сургалтад 2 албан хаагч, Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан “Хичээл сургалтын үйл ажиллагааг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй” сургалтад 5 албан хаагч тус тус хамрагдаж, чадавхжлаа.



Бага насны хүүхдийн цогц хөгжил хамтын ажиллагааны стратеги төлөвлөгөөний хүрээнд Бугат, Жаргалан сумдад эцэг эхийн клубын сургагч багш бэлтгэх сургалтын 8 дахь өдрийн хичээл онлайнаар зохион байгуулагдаж Өмнөговь аймагтай туршлагаа хуваалцан бүтээлч даалгавраа ярилцаж, уг арга хэмжээнд 24 хүн хамрагдаж, мэдээлэл солилцлоо.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр үе тэнгийнхний дээрэлхэлт, хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх "БАНХАР АРТ ТЕРАПИ ТӨСӨЛ"-ийн хүрээнд сургалт зохион байгуулж, 24 сургуулийн 1200 гаруй сурагч хамрагдаж, мэдээлэл авлаа.

“Хүмүүжлийн эерэг арга” сургалт 12 дугаар сарын 21-ний өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, тус аймгийн 25, Архангай аймгийн 15, нийт 40 албан хаагч оролцож, чадавхжлаа.

Бага насны хүүхдийн цогц хөгжил хамтын ажиллагааны стратеги төлөвлөгөөний хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Жаргалан сумд "Эцэг эхийн клуб" байгуулж нээлтээ хийлээ.



**Эрүүл мэндийн чиглэлээр:** Коронавируст (КОВИД-19)-ын халдвар батлагдсан 18 иргэнийг Нэгдсэн эмнэлэг, Эрүүл-Ирээдүй эмнэлгүүдэд хуваарилан хэвтүүллээ. Коронавирусийн халдварын онош батлагдсан 1153 тохиолдлын тоог нэгж бүрээр цахим шивэлт хийж онлайн түвшинд нэгтгэн, сан бүрдүүлж ажиллалаа. КОВИД-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамрагдвал зохих 43485 хүнээс Вакцины 1-р тунд 39246 хүн буюу 90.3 хувь, 2-р тунд 37546 буюу 86.3 хувь 3-р тунд 14396 буюу 38.3 хувь нь хамрагдаад байна. Вакцины нөөц 8725 хүн.тун байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохин байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн мэдээний сан” бүртгэлийн програмын сургалтад төрийн болон хувийн хэвшлийн 27 байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн, дүн бүртэгч 33 хүн танхимаар , 15 хүн цахимаар хамрагдлаа.

Эмнэлзүйн “Хүүхдийн өвчний цогц менежмент” сургалтыг батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 2021.12.12-14-ний өдрүүдэд зохион байгуулж нэгдсэн эмнэлгийн хүүхэд, нярай, яаралтай тусламжийн эмч, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв бүрээс 1 эмч, 1 багийн эмч нар, нийт 50 оролцогчийг хамруулан зохион байгууллаа.

Амбулаториар нийт 5887 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, томуу төст өвчинтэй 149 тохиолдол бүртгэгдлээ. Тайлант хугацаанд 75 эх эсэн мэнд амаржиж 76 хүүхдийг хүлээн авлаа. Нийт 66 мэс засал хийсэн ба түргэн тусламжийн 298 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 376 хүн өөрөө ирж үзүүлснээс 12 буюу 3.1% нь томуу, томуу төст өвчний тохиолдол байлаа. Алсын дуудлагын 3 тохиолдолд үйлчиллээ. 2021 оны эхний 11 сарын байдлаар 1184 эхээс 1191 хүүхэд амьд төрж, амьгүй төрөлт 7, нас баралт 289, хэвтэн эмчлүүлсэн 17287, ор хоног 144321, бүгд үзлэг 249230, жирэмсний хяналтад шинээр 900, шинэ хорт хавдрын өвчлөл 40, осол гэмтлийн өвчлөл 974, түргэн тусламжийн дуудлага 10424 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 20 нэгжид нийт 13 төрлийн 12732 халдварт өвчлөл бүртгэгдсэнээс цусан суулга 2,сүрьеэ 17, бруцеллёз 2, ёлом 1, тэмбүү 31, заг хүйтэн 17, трихомониаз 6, халдварт гепатит 4, салхин цэцэг 9, гар хөл амны өвчин 14, ковид-19 халдвар 12608, хачигт риккетсиоз 16, БЗ-ын бусад халдварт өвчин 5 тохиолдол байна. Ковид-19 халдварын тархалттай холбоотой онош батлагдсан халдварт өвчин бүх сумдад бүртгэгдсэн байна.

Улсын төсвийн 600.0 сая төгрөгийн санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийн дэмжих төвийн их засварыг 1-р давхрын В блок, 2-р давхрын В блок их засварын ажил үргэлжилж байна. Ажлын гүйцэтгэл 30%-тай байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад 103 ширхэг компьютер, 38 ширхэг хүчилтөрөгийн аппарат гардууллаа.

Нийт 275 үзүүлэлтээр 35 нэгжээр өмнөх оны мөн үетэй харьцуулан статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийж, дүнг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Анхан шатны эрүүл мэндийн тогтолцоонд олон нийтийн эрүүл мэндийн ажилтны менежмент нэвтрүүлсэн 5 сумын болон 3 өрхийн Эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт хийж, тайланг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүллээ.

Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Хансан панзат” ХХК-ийн Сэтгэлийн гэгээ эмэгтэйчүүдийн клиникт тусгай зөвшөөрөл олгох ажлын байрны болон АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дах салбар анагаах ухааны сургуулийн эмнэлзүйн албаны клиникт тусгай зөвшөөрөл олгох үнэлгээг тус тус хийлээ.

Эрүүл мэндийн цаг үеийн мэдээ мэдээллийг Алтай телевизээр 6 удаа, тв шторик 3, Алтай радио, МонЦаМэ агентлагаар 8 удаа, нийт 17 удаа мэдээлэл хийж, иргэдэд хүргэлээ.

Соёлын чиглэлээр. “Үндэсний бичигтэн аймаг” болох аяныг дүгнэж, “Үндэсний бичигтэн шилдэг байгууллага” болон “Монгол бичгийн шилдэг Өргөө”-г тус бүр 5 байр эзлүүлэн шалгаруулан, шагнаж урамшууллаа.

“Үндэсний бичиг өв соёл-Алтайн бахархал” уралдааны шалгарсан бүтээлүүдээр Ардын Дуу Бүжгийн “Алтай” Чуулгад үзэсгэлэн гаргаж, иргэдэд сурталчиллаа. Мөн “Шилдэг үндэсний бичигтэн” сум шалгаруулснаас гадна Үндэсний бичгийн олимпиадыг төрийн албан хаагчид, иргэд гэсэн 2 ангиллаар зохион байгуулж, шилдгүүдийг шалгаруулан шагналаа.

“Жишиг соёлын төв” шалгаруулах удирдамжийн дагуу Чандмань сумын соёлын төвийн материалыг Соёлын яаманд хүргүүлж, тус сумын Соёлын төв шалгарлаа.

“Үндэсний бичиг өв соёл-Алтайн бахархал” төслийн тайланг Соёлын яаманд хүргүүллээ.

Нийтийн номын сан. Тайлант хугацаанд 127 шинэ уншигч бүртгэн, 831 иргэнд 1503 ном олгож үйлчиллээ. Уншигчдад аман болон бичгийн 10 лавлагаа, 5 татгалзал бүртгэн, гэрээр ном олгох тасаг болон уншлага үйлчилгээний танхимаас нийт 65 ширхэг ном сэргээн засварлаж уншигчдад үйлчиллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдрийг тохиолдуулан их зохиолч Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг хэн сайн унших вэ, өөрсдийн хийсэн гар урлалын бүтээлийн үзэсгэлэн гаргах, Монгол ардын биелэгээ гэсэн 3 төрлөөр уралдаан зохион байгуулж, нийт 30 хүн оролцож, шилдгүүдээ шалгаруулж, шагналаа.

Орон нутгийг судлах музей. Түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет бус өв, өвлөгчдийн судалгаа, тайлан, хөдлөх дурсгалын тайлан мэдээг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүллээ.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг эхлүүлж, Шарга, Тонхил, Дарив сумдад 5 үл хөдлөх дурсгалын тооллогыг, Бигэр, Цогт, Чандмань, Эрдэнэ сумдад 10 үл хөдлөх дурсгалын тооллогыг тус тус хийгээд байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага: “Тамхины хяналтын тухай, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумын 36 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулан зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хүүхэд, тэдний гэр бүлд тулгамдаж буй асуудлыг сонсох, зөвлөгөө өгөх, хүүхэд хөгжүүлэх төвийн хүүхдүүдийн жилийн хугацаанд сурсан мэдсэн зүйлийг эцэг эхчүүдэд танилцуулах зорилгоор “Халуун сэтгэл-дулаан инээмсэглэл” арга хэмжээг 6 дахь жилдээ зохион байгуулж, 125 хүүхэд, эцэг эх, бизнес эрхлэгч

эмэгтэйчүүдийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд 53 бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийлээ.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2021 оны 3 дахь удаагийн хуралдаанаар “Оны онцлох хүүхэд”-ийг 8 номинациар шалгарууллаа.

“Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” аяныг үнэлж дүгнэх, оны шилдэг ГХУСАС зөвлөл, хамтарсан баг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, эхний 4 байрыг шалгаруулан, нийт 3.0 сая төгрөгийг шагналд зарцууллаа.

Мөн төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 2021 оны “Гэр бүлд ээлтэй шилдэг эцэг эхийн зөвлөл”-ийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Залуучуудыг ажлын байраар хангаж, орон нутагтаа ажиллаж, амьдрах орчин нөхцөлөөр хангасан байгууллагын судалгаагаар 2021 онд их, дээд сургууль төгссөн 62 төгсөгч шинээр ажлын байраар хангагдсан байна.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Аймгийн хэмжээнд нийт 741 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгэлтэй байна. Тайлант сард аймгийн хэмжээнд 41 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдад, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Хөдөлмөр сургалтын танхим”-ыг 2-р сургуульд байгуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 11.9 сая төгрөг зарцууллаа.

Нийгмийн халамжийн сангаас Халамжийн тэтгэвэр 1397 иргэнд 385.3 сая төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмж 1226 иргэнд 105.7 сая төгрөг, Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 744 иргэнд 171.5 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 244 иргэнд 34.0 сая төгрөг, Ахмад настны хөнгөлөлт, тусламж 130 иргэнд 18.3 сая төгрөг, Жирэмсэн эхийн тэтгэмж 361 иргэнд 13.1 сая төгрөг, Цалинтай эхийн тэтгэмж 2860 эхэд 140.8 сая төгрөг, Алдарт эхийн одон 4 эхэд 400.0 мян төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүллээ.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Баруун бүсийн спортын салбарын уулзалт, зөвлөгөөн, тэмцээн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 16-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 18 албан хаагч оролцож, мэдээлэл солилцлоо.

Ахмадын аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, 14 багийн 102 тамирчин оролцлоо.

“Баруун бүс-Түмний манлай 2021” өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаан 2021 оны 12 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 5 аймгийн 27 байгууллагын 300 гаруй өсвөрийн бөхчүүд хүч сорин барилдлаа.

Хэрэглэлгүй /classic/ хэвтээ шахалтын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдаж, 12 жинд 71 тамирчин оролцон хүчээ сорилоо.

Иргэдийн спортын наадмыг 3 төрлөөр 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 37 байгууллагын 1004 тамирчин 114 багц медалийн төлөө өрсөлдөж, дүнгээ гаргалаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан суугаа волейбол, 100-н буудалт даамны тэмцээнийг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж 4 багийн 48 тамирчин оролцож, хурд хүч, оюунаа сорилоо.

## ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Ашигт малтмалын MV -021537 тусгай зөвшөөрлийн дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Хан-Алтай ресурс ХХК-ийн Хан алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төслийн 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, арга зүйн зөвлөгөө өглөө.

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 сарын 15-ны өдрийн А/475 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаад хамтран ажиллаж менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэлээ. Төлөвлөгөөний хэрэгжилт 90.2 хувьтай байна.

Ус цаг уур орчны шинжилгээний чиглэлээр: Чандмань, Эрдэнэ, Дэлгэр, Гуулин, Тайшир сумдад агаар бохирдуулах эх үүсвэрийн хяналтын тооллого хийж, заавар зөвлөмж өглөө. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн сургалтыг цахимаар зохион байгуулж, цаг уурын мэргэжлийн албан хаагчид хамрагдаж чадавхжлаа.

Нислэгийн үйлчилгээнд 3 удаа бодит болон урьдчилсан мэдээний хангалтыг хийсэн. Хагас хоног, хоног, 5 хоногийн урьдчилсан мэдээ, 7 хоногийн төлөв, хоногийн тойм, сарын мэдээг цаг тухай бүр байгууллагын албаны цахим хуудаст байршуулан иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Цасны мэдээ: 2021 оны 12-р сарын 20-ны байдлаар Баян-Уулд 2 см, Хөхморьт, Тайшир, Халиун, Цогт сумдад 0 см зузаан, Дэлгэрт 5-9 баллын бүрхэц тогтсон. Тус аймгийн нийт нутгийн 20 хувьд цасан бүрхүүл тогтсон байна.

## НАЙМ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Аж ахуйн нэгж байгууллагуудын 2021 оны эрсдэлийн үнэлгээг хийж байна.

*Байгаль орчин, геологи уул уурхай, газар геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:*

Тайлант хугацаанд 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт хийж, 18 заалт бүхий 1 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, хууль бусаар тарвага агнасан 1 иргэнд 150.0 мянган төгрөгийн торгууль, 476.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.



Хураагдсан тарвагыг Зооноз өвчин судлалын төвд шилжүүлэн устгаж буй байдал

**Дэд бүтцийн хяналтаар:** Аймгийн Засаг даргын 2021 оны А/584, А/585 дугаар захирамжийн хүрээнд Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Хан Алтай Ресурс ХХК-ийн шатахуун хадгалах, түгээх станцын угсралт, гүйцэтгэлийн байдалд болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр, төслийн хүрээнд хэрэгжсэн Нэгдсэн эмнэлгийн ариутгал үйлчилгээний төв тасгийн зориулалттай барилга угсралтын ажлын явцад үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Хэмжил зүйн чиглэлээр 1 объектын өргөх механизмд төлөвлөгөөт хяналт хийж 12 зөрчил илрүүлэн 5 зөрчлийг газар дээр нь арилгуулж, албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Мөн шалгалтын явцад эмчилгээ, оношилгоонд ашиглаж байгаа 51 хэмжих хэрэгслийг улсын баталгаажуулалтад хамрууллаа.

Хүнсний чанар, эрүүл ахуйн чиглэлээр: МХЕГ-ын даргын баталсан 01/05 дугаар удирдамжийн дагуу хүнсний үйлдвэрийн 5, хүнсний худалдааны 10, хоол үйлдвэрлэлийн 9 объектыг тус тус хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж бүтээгдэхүүний 10, арчдасны 140 дээж авч Нэгдсэн лабораторид шинжлүүллээ. Илэрсэн зөрчлийг арилгуулж 3 иргэнд 300.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Иргэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн 20 хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүллээ.

Нэгдсэн лаборатори. Лабораторид 8 иргэн, 2 байгууллага, 13 аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 20 сорьц 67 үзүүлэлт, ундны усны 5 сорьц 64 үзүүлэлт, хөрсний 1 сорьц 4 үзүүлэлт, диализын усны 1 сорьц 3 үзүүлэлт, ариутгалын бодисын 1 сорьц 1 үзүүлэлт, арчдасны 138 сорьц 138 үзүүлэлтээр хими, нян, хорио цээрийн шинжилгээг хийж, ундны усны 3 сорьц 5 үзүүлэлт, хөрсний 1 сорьц 1 үзүүлэлт, хүнсний бүтээгдэхүүний 6 сорьц 7 үзүүлэлт, арчдасны 2 сорьц 2 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр 194,8 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүллээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР